

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ХЭРЭГЖИЛТИЙГ
ТООЦООГҮЙ БАЙНА.

**АУДИТЫН СЭДЭВ “БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ
ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”**

АУДИТЫН КОД: ГАА-2023/30/-ШТА-НА

БУЛГАН АЙМАГ
2023 ОН

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Мөнхтуяа
Утас: 7034-2716 Цахим хаяг: Monkhtuyar@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlhamg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Золжаргал
Утас: 7034-2495 Цахим хаяг: zoljargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
bulgan@audit.gov.mn



БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 4/10

Булган сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Эрх, үүрэг шилжүүлэх тухай" 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн шууд тайлагнах аудитын тайланг (БУА-2023/30-4-ШТА-НА) баталсугай.


2. "Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-ээр илэрсэн алдаа, зөрчлийг нэг дүгээр хавсралтаар баталсугай.

3. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн дотор хариу ирүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга (Д.Эрдэнэбат), аймгийн Засаг дарга (Б.Ариун-Эрдэнэ), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нийцлийн аудитын дүнг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн дотор тооцож, танилцуулахыг ахлах аудитор (П.Мөнхтуяа), аудитын менежер (Ж.Энхцоодол) нарт үүрэг болгосугай.

5. Аудитын тайланг Говь-Алтай аймгийн Төрийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

D:\bnchig_hereg\2023\tushaal\TAtushaal.doc

006010029

АГУУЛГА

<u>Товчилсон үгийн тайлбар</u>	4
Хүснэгтийн товьёг	5
<u>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</u>	6-7
А. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаж байгаа ч бусад эрх зүйн акттай нийцэхгүй байна	8-9
А1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн 14 арга хэмжээнээс 12 ажил хийгдэж байгаа нь дунджаар 94 хувиар илэрхийлэгдэж байна	8-9
А1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь холбогдох хууль тогтоомж, зарим эрх зүйн акттай нийцэхгүй байна	8-9
А1.2. Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталж, ногоон хөгжлийн бодлогод дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хэрэгжилт 2021-2022 онуудад дунджаар 94 хувийн хэрэгжилтэй байна	9-10
А1.3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан менежментийн төлөвлөгөөг баталж байгаа ч ан агнуурийн менежментийн төлөвлөгөөг зарим сумдад менежмент хариуцагчгүй тул боловсруулж ажиллаагүй байна	11
А2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнүүлж ажилласан байна	12
А2.1. БОАЖ-ийн сайд аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгажээ	12
А2.2. Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусган ажилласан байна	12-13
Б. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын хэрэгжилт сул байна	13
Б1. Төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлтийг төлөвлөж батлуулсан ч орлогыг илүү дутуу төвлөрүүлсэн байна	13
Б1.1. Монгол Улсын байгалийн нөөцийг тогтоож, ашиглах төрөл, дээд хэмжээг үндэслэлтэй төлөвлөөгүй байна	13
Б1.2. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу 2021, 2022 онуудад байгаль хамгаалах нөхөн сэргээхэд шаардагдах эх үүсвэрийг бүрдүүлж, хуваарилаагүй байна	13-14
Б1.3. Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож байгаа ч зарим сумд нь батлагдсан тоо хэмжээнээс илүү зөвшөөрлийн бичиг олгож, ус рашааны төлбөр авах ажлыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна	14-15
Б1.4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөж, ногдуулан, бүрэн төвлөрүүлээгүй орлого дутуу төвлөрүүлжээ	15-17
Б2. Төлбөрийн орлогын хэсгийн хуваарилалтыг хуульд заасан хэмжээгээр төлөвлөөгүй байна	17

Б.2.1. Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу 2023 онд төлөвлөсөн байна.....	17-18
Б.2.2. Төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 2021, 2022 онуудад хуваарилаагүй, 2023 оноос эхлэн хуваарилжээ.....	18-20
В.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, хийж үр дүнг тооцоогүй байна.....	20
В.1. Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан үнэн зөв илэрхийлэгдээгүй, төрийн байгууллагуудын цахим мэдээллийн сан уялдаагүйгээс зөрүүтэй тайлагнагдаж байна.....	20
В1.1 Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан бүрдүүлэлт, ил тод байдал хангагдсан ч журмын хэрэгжилт хангалтгүй байна.....	20
В1.2 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаатай ч цахим мэдээллийн сан, системүүд хоорондоо уялдаа холбоогүй байна.....	20-21
В.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийсэн боловч үр дүн хэрэгжилтийг тооцож дүгнээгүй байна.....	21
В2.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн байгууллага нь байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт, шалгалт хийгдсэн боловч үр дүн хэрэгжилтийг тооцоогүй байна.....	21
В2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хүрээнд хамтарсан хяналт шалгалт хийсэн нь үр дүн хэрэгжилтийг тооцоогүй байна.....	21-22
ДҮГНЭЛТ.....	21-23
ЗӨВЛӨМЖ.....	23

Товчилсон үгийн тайлбар

БНХТТХ	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
БОХТХ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
ОТХ	Ойн тухай хууль
БОНБҮТХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
ТТБТХ	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
ГТХ	Газрын тухай хууль
ГТТХ	Газрын төлбөрийн тухай хууль
БОХНСАХЗТОХБЗТЖ	Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах тайлагнах журам
ХБТТУТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Батлагдсан менежментийн төлөвлөгөөний тоо	9
Хүснэгт 2	2021-2023 онд 4 хуулийн этгээдэд усны дүгнэлт	14
Хүснэгт 3	Орлогын гүйцэтгэл	14
Хүснэгт 4	Ус, рашаан ашигласан төлбөрийн орлогын 2021, 2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл /Хавсралт-1/	15
Хүснэгт 5	Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, үйлдвэрлэлийн зориулалттай усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөгөө, гүйцэтгэл /Хавсралт-2/	15
Хүснэгт 6	Орлогын гүйцэтгэлийн дүн, ТЕГ-ын дүн хоорондын зөрүү	16
Хүснэгт 7	Зардлын хуваарилалт	17
Хүснэгт-8	Хэрэгжээгүй төсөл арга хэмжээ	17
Хүснэгт 9	Цахим системийн мэдээ оруулалтын байдал /Хавсралт-3/	19
Хүснэгт 10	Усны нөөц ашиглалтын мэдээллийн зөрүү	19

Графикийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Төлөвлөсөн асуудлын хүрэх түвшин	8

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Уул уурхайн нөхөн сэргээлт хийгдээгүй газруудыг зураг	15

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл МУЕА-ын 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.</p>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх.- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх.- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх.
<p>Аудитын хязгаарлалт</p>	<p>Аудитад Сангийн яам, БОАЖЯ, Усны газар, Ойн газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн зураг, Татварын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга, аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, БОАЖГ, ГХБХБГ, Усны сав газрын харилцаа, Сум дундын ойн ангийн 2021-2023 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.</p> <p>.....</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 687-6:2020, Нийцлийн аудитын зарчим, МУЕА-ын баталсан Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга, болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.</p>

<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Мөнхтуяа, Д.Анхбаяр, аудитор Г.Цэрэнлхам, Б.Золжаргал нар хийж гүйцэтгэлээ.</p> <p>Аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитын талбарын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хүртэл гүйцэтгэж, тайлагналын ажлыг 2022 оны 06 дугаар сарын 19-ний өдөр дуусгавар болгон аудитыг үе шатны хяналтаар хянуулж, аудитын тайлан, нотлох баримтыг бэлтгэн ажиллалаа.</p>
<p>Хүндрэл бэрхшээл</p>	<p>Аймгийн Татварын хэлтэс нь сар бүр орлогын тайлан мэдээг СТСХ-т хүргүүлэн ажиллаж байгаа ч аудитын явцад ТЕГ-аас аймгийн Татварын хэлтэст ямар нэгэн мэдээлэл өгөхгүй гэсэн чиглэл өгсний дагуу хүснэгтэд мэдээлсэн зөрүүний талаар асууж тулган баталгаажуулах боломж олгоогүй болно.</p>
<p>Үндсэн мэдээлэл</p>	<p>Аймаг байгалийн нөөц ашигласны орлогыг, байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах зардлыг арга хэмжээ тус бүрээр зардлыг тооцон төлөвлөж 2021, 2022, 2023 онуудын Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн II/09, 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн V/04, 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII тоот тогтоолуудаар тус тус батлуулсан байна.</p> <p>Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн дүнг товч дурдвал: Газрын төлбөрийн орлогыг 2021 онд 891.4, 2022 онд 1318.3, 2023 онд 1347.7, усны төлбөрийн орлогыг 2021 онд 14501.1, 2022 онд 16258.0, 2023 онд 27585.2, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 522.1, 2022 онд 551.8, 2023 онд 551.6, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 6.1, 2022 онд 13.6, 2023 онд 7.6, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 1.0, 2022 онд 0.3, 2023 онд 0.3 сая төгрөгөөр тус тус төвлөрүүлэхээр баталсан байна.</p> <p>Нийт 2021 онд 15688.3, 2022 онд 17702.2, 2023 онд 29153.4 сая төгрөгөөр төлөвлөснийг өмнөх оны орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 2022 онд 11.3, 2023 онд 39.2 хувиар тус тус нэмэгдүүлж төлөвлөсөн байна.</p> <p>Орлогын гүйцэтгэл 2021 онд 19459.1, 2022 онд 20915.7, 2023 оны эхний 6 сарын байдлаар 13866.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг 2021 онд 34 арга хэмжээнд 4271.9, 2022 онд 45 арга хэмжээнд 5248.2, 2023 онд 42 арга хэмжээнд 5279.8 сая төгрөг тус тус зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 2021 онд 4131.1, 2022 онд 4240.9 сая төгрөгийг тус тус зарцуулснаар тайлагнаж, 2023 оны 06 дугаар сарын байдлаар 783.8 сая төгрөг зарцуулагдсан байна.</p>

А.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаж байгаа ч бусад эрх зүйн акттай нийцэхгүй байна.

А1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн 14 арга хэмжээнээс 12 ажил хийгдэж байгаа нь дунджаар 94 хувь байна.

А1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь холбогдох хууль тогтоомж, зарим эрх зүйн акттай нийцэхгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь зарим хууль тогтоомж болон эрх зүйн акттай хуулийн заалт болон хугацааны хувьд зөрүүтэй байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-д “орон нутгийн төсвийн суурь зарлага” гэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын болон орон нутгийн чиг үүрэг, төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагын нийлбэрийг”, Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолын хавсралт “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 1.2.1-д “орон нутгийн төсвийн суурь зарлага” гэж заасан ч Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журмын 3.3¹-т зааснаар орон нутгийн суурь зарлагыг санхүүжүүлэхгүй,
- 2021 онд батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хууль”-д заасны дагуу тогтооно гэж заасан ч хууль нь батлагдаагүй;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан боловч Зөрчлийн тухай хуульд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тусгагдаагүй;
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/282 дугаар тушаалын хавсралт “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 2.3², 2.4³, 2.5⁴, 2.6⁵-д заасан хугацаа нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасан хугацаатай зөрүүтэй тусгагдсан,

¹ Энэ журмын 3.1-д заасан нөхцөл, хязгаарыг хангаагүй тохиолдолд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлэхгүй

² Ойн анги өөрийн хариуцсан сүмдын ойн сан дахь хуш модны самрын ургацын мэдээ, дүгнэлтийг аймаг, нийслэлийн Байгаль орчны газарт 08 дугаар сарын 5-ны дотор хүргүүлнэ.

³ Аймаг, нийслэлийн Засаг дарга хуш модны самар бэлтгэх эсэх талаарх саналаа Ойн ангиас судлан тогтоосон ургацын мэдээ, Байгаль орчны газрын дүгнэлтийн хамт Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн оны 8 дугаар сарын 10-ны дотор багтаан хүргүүлнэ.

⁴ Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн хуш модны самар бэлтгэх эсэх талаарх санал, ургацын мэдээнд хяналтын судалгааг хийж, аль бүс нутгаас хуш модны самрыг ямар зориулалтаар бэлтгэх талаарх дүгнэлтийг тухайн оны 09 дүгээр сарын 1-ний дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

⁵ Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь журмын 2.5-т заасан дүгнэлтийг үндэслэн хуш модны самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах эсвэл хориглох тухай шийдвэр, түүж бэлтгэх нөөцийн дээд хэмжээг тухайн оны 09 дүгээр сарын 10-ны дотор бүсчлэн тогтооно.

- Байгал хамгаалах тухай хуульд байгаль хамгаалагчийг томилох, эрх үүрэг, хяналт тавьж ажиллах талаар тусгаснаас ойн нөөцийн буюу түлээний эрхийн бичиг үнэт цаасны тооцоо хийх, архивын нэгж болгоогүй, сумын санхүүгийн алба болон татварын байцаагч нартай тооцоо нийлж баталгаажуулаагүй, сумдын байгаль хамгаалагч нарын 2021-2022 онуудад олгосон үнэт цаас задгай үдэгдээгүй, эзэнгүйдэх эрсдэл үүсэж байгаа,
- Төсвийн тухай хуулийн 8.4.2.төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй төсвийн шууд захирагч жил бүрийн 8 дугаар сарын 01-ний дотор жилийн төсвийн төслөө харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх хугацаатай байдаг.
- Гэтэл Засгийн газар, БОАЖЯ-наас дараа онд тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тухайн оны 12 дугаар сард баталж байгаа нь ан амьтан ашигласны төлбөрийн орлогыг зөрүүтэй төлөвлөх нөхцөл, шалтгааныг үүсгэж байна.

А1.2. Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталж, ногоон хөгжлийн бодлогод дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хэрэгжилт 2021-2022 онуудад дунджаар 94 хувийн хэрэгжилтэй байна.

Булган аймаг нь 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн аймгийн ИТХ-ын II/05 дугаар тогтоолоор “Булган аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын хавсралтаар аймгийг хөгжүүлэх чиглэлийг батлан ажиллаж байна.

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1⁶, 6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4⁷, 6 дугаар зүйлийн 7⁸, 6 дугаар зүйлийн 8⁹, 6 дугаар зүйлийн 9¹⁰, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн баримт бичигтэй тус тус уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тооцож боловсруулжээ.

Үүнд: Аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан “Ногоон хөгжил” дэд сэдвийн хүрээнд 5 асуудлаар суурь түвшинг хүрэх түвшингээр нь тооцон гаргажээ.

Төлөвлөсөн асуудлын хүрэх түвшнийг графикаар харуулбал:

/График-1/

⁶ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилгоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий дараах төрөлтэй байна.

⁷ Байгаль орчны зорилгот хөтөлбөр.

⁸ Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

⁹ Дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна.

¹⁰ Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.



Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн дагуу 2021-2023 онуудад “Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлж 14 арга хэмжээ төлөвлөж гүйцэтгэлээр 2021 онд 10 арга хэмжээний ажил 80-100 хувийн хэрэгжилттэй 4 ажил хийгдээгүй, 2022 онд төлөвлөсөн арга хэмжээний ажлуудаас 12 ажил нь 70-100, 2 ажил нь хийгдээгүй, 2023 онд 13 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс эхний 5 сарын байдлаар 6 ажил хэрэгжих шатандаа явагдаж байна.

Хэрэгжсэн ажлуудаас товч дурдвал: 2021 онд Усны нөөц усан хангамжийг сайжруулахаар 10 булаг шандыг хашаажуулсан, ойн сангийн 20 хувийг хамгаалж 306 га талбайд ойг нөхөн сэргээх ажлыг хийж сангийн 3 хувийг ойжуулсан, 28674 га газрын 1752.0 тн, 95 гол горхи, нуур, уст цэгийн 155.8 тн хог хаягдлыг цэвэрлэн, үхсэн мал амьтны 5463 сэг зэмийг устган халдваргүйжүүлсэн, аймгийн төвийн 200 айл өрхийг эко ариун цэврийн байгууламжтай болгосон, уул уурхайн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 4 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоож, 2 аж ахуйн нэгжид 288.2 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, 7 аж ахуйн нэгжид 40.5 сая төгрөгийн торгууль, усны төлбөрт 325.9, газрын төлбөрт 109.3 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газрууд болон музейн үзмэрүүдийн “Виртуал “ танилцуулгыг “Дижитал сольюшнс” ХХК 24.5 сая төгрөгөөр гүйцэтгэж, жуулчид, аялагчдад зориулсан газрын зураг, танилцуулгыг шинэчлэн гаргах ажлын гүйцэтгэгчээр “МРМ” ХХК шалгарч, 14.7 сая төгрөгөөр англи, монгол хэлээр 6500 ширхгийг хэвлэн, хүлээлгэж өгсөн, Дашинчилэн суманд “Өвөр хадат” гэх газарт 2, “Овоо” гэх газарт 2, Бүрэгхангай сумын “Цоохор морьт” гэх газарт 2, “Наран гоулд” ХХК-ийн талбайд хууль бус алт олборлолтын 1 хэрэг гарч, 29.5 сая төгрөгийн хохирол тогтоолгох ажил хийгдсэн, 2715 нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэжээ.

Булган сумын нийтийн эзэмшлийн талбайн 9 байршилд, 18 ширхэг соруулдаг жорлон барих ажлыг гүйцэтгэсэн, усны тоо бүртгэлийн судалгаагаар 418 гол горхи, 152 нуур тойром, 805 булаг шанд, 9 хөв цөөрөм, 1581 худаг тоологджээ.

Эдгээр хийгдсэн ажлуудаас үзэхэд 2021-2022 онуудад ногоон хөгжлийн бодлогын арга хэмжээний хүрээнд нийт 14 арга хэмжээнээс 12 ажил нь хийгдэж дунджаар 94 хувийн үзүүлэлттэй байна.

А1.3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан менежментийн төлөвлөгөөг баталж байгаа ч ан агнуурийн менежментийн төлөвлөгөөг зарим сумдад менежмент хариуцагчгүй тул боловсруулаагүй байна.

Аймгийн БОАЖГ нь 2021-2023 онуудад ойн нөхөрлөлийн, усны, уул уурхайн, ан, агнуурын менежментийн төлөвлөгөөг хуульд заасны дагуу боловсруулан батлуулжээ.

Аймгийн “Ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөө”-г 2019 онд батлуулсан боловч Хутаг-Өндөр, Могод сумдаас бусад сумдад менежмент хариуцагчгүй учраас ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй, аймгийн ИТХ-ын “Тусгай болон ахуйн зориулалтаар агнах, барих, амьтдын дээд хязгаарыг батлах тухай” 2021, 2022 онуудад баталсан тогтоолуудыг мөрдөн ажилласан байна.

Аймаг сумын хэмжээнд 2021-2023 онуудад байгалийн нөөцтэй холбогдуулан менежментийн төлөвлөгөөг боловсруулан ажилласан төрөл, тоон мэдээллийг хүснэгтээр харуулбал:

№	Төрөл	Батлагдсан менежментийн төлөвлөгөөний тоо		
		2021 он	2022 он	2023 он
1	Ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө	83	77	44
2	Ойн менежментийн төлөвлөгөө	20	25	30
3	Уул уурхайн менежментийн төлөвлөгөө	13	14	6
4	Ан агнуурын менежментийн төлөвлөгөө	2	2	0
Нийт дүн		118	118	80

2021 онд 118, 2022 онд 118, 2023 онд 80 буюу өмнөх 2 оноос 38 менежментийн төлөвлөгөө хийгдээгүй буурсан үзүүлэлтэй байна.

Уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, компаниуд нь 2021, 2022 онуудад усны гэрээ байгуулан ажиллажээ.

Аймаг, сумын ИТХ нь Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх заалтын 2-т¹¹ тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн баталдаг.

Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа газар зохион байгуулалтын суурь төлөвлөгөөнүүд болон иргэдээс санал авч тухайн онд аймаг, орон нутгийн төсвийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудтай уялдуулан боловсруулж сумын ИТХ-аар батлуулан, хэрэгжилтийг сумын Засаг дарга ханган ажилладаг.

Булган аймаг нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2021-2023 онуудад аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн II/09, 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн V/04, 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 тоот тогтоолуудаар боловсруулахаар баталсан байна.

Тус тогтоолоор 2021 онд 160.0, 2022 онд 500.0 сая төгрөгийг тус тус баталж, гүйцэтгэлээр 2021 онд 7 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж тухайн сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж гүйцэтгэгчээр шалгарсан “Вектор мэл” ХХК-ны дансанд баталсан санхүүжилтийг бүрэн олгож, 2022 оны 08 дугаар сарын 01-ны өдөр газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг хүлээн авч актаар баталгаажуулсан байна.

¹¹ нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах

Үүнд: Баян-агт, Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Сайхан, Рашаант гэсэн сумдын нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулжээ.

А2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнүүлж ажилласан байна.

А2.1. БОАЖ-ийн сайд аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгажээ.

Булган аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2021 онд хамтран ажиллах гэрээний 1.5-д дахь заалт “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хууль болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д зааснаар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг зориулалтын дагуу зарцуулах арга хэмжээг 70 хувь, 2020 онд Усны нөөцийг хамгаалах, усан хангамжийг сайжруулах чиглэлээр Булаг шандын эхийг хашиж хамгаалах, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн тэмдэгжүүлэлд, усны тоо бүртгэл, үерийн далан засварлах, цэвэр усны даралтад цамхаг барих, хөв цөөрөм барих зэрэг ажилд 1512.9 сая төгрөг, амьтны нөөцийг хамгаалах, өсөн үржих нөхцөлөөр хангах чиглэлээр нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх, үржлийн үед хяналт шалгалтыг хийх, сэргээн нутагшуулах ажилд 35.0 сая төгрөг, ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажил, арчилгааны огтлолт, ой, хээрийн түймрээс сэргийлэх сургалт зэрэг ойн аж ахуйн арга хэмжээнд 496.5 сая төгрөгийг хуулийн хувь хэмжээгээр зарцуулан ажиллаж 100 хувь биелүүлсэн байна.

Булган аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах 22-04 дүгээр гэрээний 1.3-д дахь заалт “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хууль болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д зааснаар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтын хүрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох ажлын төсөвтэй холбогдуулан байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд тусган сум тус бүр төлөвлөн зохион байгуулан гэрээг дүгнүүлж ажилласан байна.

Гэрээний 1.4-д “2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогоос зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг Байгаль орчны төсөв зардлын мэдээллийн санд журамд заагдсан хугацаанд тогтмол оруулах” гэсэн заалтыг хэрэгжүүлсэн www.eic.mn сайтаар 2023 оноос эхлэн мэдээлж ажиллажээ.

А2.2. Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусган ажилласан байна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4.4-д “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хууль болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д зааснаар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг зориулалтын дагуу зарцуулах”, 1.4.5-д “2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогоос зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг Байгаль орчны төсөв зардлын мэдээллийн санд журамд заагдсан хугацаанд тогтмол оруулах” гэсэн заалтын дагуу

ажиллаж БОАЖГ аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2021 онд 89.2, 2022 онд 88.8 хувиар дүгнүүлсэн байна.

Б. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын хэрэгжилт сул байна.

Б1.Төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлтийг төлөвлөж батлуулсан ч орлогыг илүү дутуу төвлөрүүлсэн байна.

Б1.1. Монгол Улсын байгалийн нөөцийг тогтоож, ашиглах төрөл, дээд хэмжээг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

БОАЖГ нь жил бүр сумдаас байгалийн нөөц ашиглах тоо хэмжээ, саналыг авч төлөвлөлтийг гарган БОАЖЯ-нд хүргүүлснээр Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д¹² заасан бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020 оны А/599, 2021 оны А/217, 2022 оны А/327 дугаар тушаалуудаар ойгоос мод бэлтгэх, 2022 оны А/372 тоот “ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох”, тушаалаар, дээд хязгаар тогтоож өгсний дагуу аймгийн ИТХ жил бүр сум тус бүрээр тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хязгаарыг баталж өгсөн ч 2023 онд Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 444 дугаар “Тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо толгойг батлах тухай тогтоол”-ыг үндэслэж БОАЖЯ-ны сайд аймаг, сумаар агнуурын амьтны тоо хэмжээг баталсан тушаал гарсан гэх боловч аймгийн БОАЖГ-т ирүүлж тогтоолын хэрэгжилтийг хангаагүй, аймгийн хэмжээнд усны нөөцийг тогтоогоогүй, ашиглах дээд хэмжээг үндэслэж төлөвлөөгүй нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т¹³, 24 дүгээр зүйлийн 2-т¹⁴ гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Мөн БОАЖЯ-ны сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/701 тоот тушаалаар баталсан тусгай болон ахуйн зориулалтаар агнах, барих амьтдын дээд хязгаарт загас агнуурыг тоог 1500 ш-ээр тогтоосныг аймгийн ИТХ-р батлахдаа 2021 онд ахуйн зориулалтаар загас агнах, барих тоо хэмжээг 1700 ш-ээр буюу 200 ш-ээр илүү баталжээ.

Аймгийн газрын төлбөрийн орлогын төлөвлөлтийг 13 төрлөөр Газрын төлбөрийн тухай хуулийн 6, 7, 9 дүгээр зүйл, Засгийн газрын 2018 оны 182 дугаар “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь, үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай”, аймаг, сумдын ИТХ-ын “Газрын төлбөрийн бүсийн зураг, хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолуудыг үндэслэн тооцож төсвийн саналыг 2021 онд 588.7, 2022 онд 721.0, 2023 онд 1048.1 сая төгрөгөөр төлөвлөж аймгийн СТСХ-т хүргүүлж газрын төлбөрийн орлогыг 2021 онд 891.4, 2022 онд 1318.2, 2023 онд 1347.7 сая төгрөгөөр тус тус орлогыг батлуулсан байна.

Газрын төлбөрийн ногдуулалтыг төлөвлөхдөө сум тус бүрээс газрын төлбөрийн орлогын төлөвлөлт болон саналыг авч тусгадаггүй, программаас хагас жилийн байдлаар мэдээллийг татаж авч төлөвлөсөнд өмнөх онд гүйцэтгэсэн “Аймгийн төсвийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт үр дүн”-д хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар зөвлөмж өгч ажилласан.

Б1.2.Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу 2021, 2022 онуудад байгаль хамгаалах нөхөн сэргээхэд шаардагдах эх үүсвэрийг бүрдүүлж, хуваарилаагүй байна.

¹² хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглаж болох ой, ургамал, амьтны тоо хэмжээг тодорхойлж, экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бүс нутагт байгалийн зарим төрлийн баялгийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох

¹³ нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох

¹⁴ Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хуульд заасны дагуу тогтооно

Аймгийн байгалийн нөөцийн төлбөрийн орлогыг жил бүр төлөвлөж байгаа ч 2021, 2022 онуудад байгаль хамгаалах нөхөн сэргээхэд шаардагдах эх үүсвэрийг бүрдүүлж, хуваарилаагүй, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг батлуулсан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д¹⁵, 13 дугаар зүйлийн 2-т¹⁶ гэсэн заалтуудыг мөрдлөг болгон ажиллаагүй, 2023 оноос эхлэн Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгал орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу байгалийн нөөцийн орлогын бүрдүүлэлт, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын хуваарилалтыг сум тус бүрээр тооцон хуваарилжээ.

Б1.3.Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож байгаа ч зарим сумд нь батлагдсан тоо хэмжээнээс илүү зөвшөөрлийн бичиг олгож, ус рашааны төлбөр авах ажлыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Байгалийн нөөц ашиглах эрхийн дээд хязгаарыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан тушаалыг үндэслэн аймгийн ИТХ-ын тогтоол батлагдаж, тогтоол шийдвэрийг сумдад хүргүүлэн ажиллаж байгаль хамгаалагч эрхийн бичгийг олгож байна.

Аймгийн хэмжээнд 2021-2023 онуудад иргэн, хуулийн этгээд, нөхөрлөлийн ургаа мод огтолж, түүний үндсэн хэсгээс бэлтгэсэн хэрэглээний мод, түлээ ашиглагч зөвшөөрсөн хэмжээ 19651, 16507, 15311 байснаас 17270.2, 14927, 1000 шоо метр.кубыг, ойгоос хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүүг цэвэрлэж түлээ бэлтгэх 76276, 101502, 112079 ашиглагчаас 93391.5, 74730, 25000 шоо метр.кубыг, ойн дагалт баялгийн нөөцийн 2022 онд ашиглагчийн 323201 шоо метр.кубыг бүрэн ашиглажээ.

Аймгийн ИТХ-ын аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн II/08, 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн V/06 тоот “Тусгай болон ахуйн зориулалтаар агнах, барих, амьтдын дээд хязгаарыг батлах тухай” тогтоож тогтоол гарсан ч зарим сумд нь ан агнах тоо хэмжээний дагуу олгоогүй, илүү зөвшөөрлийн бичиг олгосон байна. Үүнд:

- Тэшиг сум нь 2022 онд ахуйн зориулалтаар барих загасыг 400 ширхгээр баталсан байхад 340 буюу 40 загасаар илүү, ан амьтны нөөцийн орлогыг татвар ногдох дүнгээр тооцон эрхийн бичигт бичилт хийгээгүй, орлогыг 185.0 мянган төгрөгөөр илүү төвлөрүүлсэн,
- Хутаг-Өндөр сум 2021 онд ахуйн зориулалтаар агнах загасыг 400 тоо ширхгээр батлаад 420 буюу 20, 2022 онд 300 загасны эрх олгосноос 576 буюу 276 тоогоор тус тус илүү агнасан нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.2.2¹⁷, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 4.3¹⁸ гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Мөн сумдын Засаг дарга нар ус ашиглаж байгаа хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар рашаан-эмчилгээ, сувилгааны зориулалтаар рашаан ашигласан усны төлбөр авах

¹⁵Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид "төлбөрийн орлогын хэсэг" гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

¹⁶Төлбөрийн орлогын хэсгийг дор дурдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлнэ.

¹⁷иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг хууль тогтоомжийн дагуу олгох

¹⁸ Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ

ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-д¹⁹, 28 дугаар зүйлийн 28.6-д²⁰ гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй.

2021-2023 онд 4 хуулийн этгээдэд усны дүгнэлт гаргасан байна. Үүнд:

Хүснэгт-2

/мян.төг/

№	ААНБ, ХХК	Дүгнэлт гаргуулсан он	Усны төлбөр
1	Булганмах маркет ХХК	2021	1403.5
2	Грандма спринг спа ХХК	2021	29.1
3	Мойлт шилтгээн	2022	8.1
4	Уньтын рашаан ХХК	2023	240.8
Нийт дүн			1681.5

Аймгийн хэмжээнд аялал жуулчлал, амралт сувиллын үйл ажиллагаа эрхэлдэг 217 аж ахуйн нэгж, иргэн бүртгэлтэйгээс улирлаар болон тогтмол үйл ажиллагаа явуулдаг 140 орчим аж ахуй нэгжүүд байна.

Эдгээр аж ахуй нэгж, иргэд усны дүгнэлт гаргуулаагүй байгаа нь сумдын Засаг дарга болон БОАЖГ-ын ажлын хариуцлагагүйгээс усны дүгнэлтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Цаашид байгалийн нөөц ашигласны тухай хууль болон болон бусад хууль журмын хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.

Б1.4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөж, ногдуулан, бүрэн төвлөрүүлээгүй орлого дутуу төвлөрүүлжээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орох орон нутгийн төсвийн суурь орлогыг 2021 онд 15922.7, 2022 онд 18142.0, 2023 онд 29492.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2021 онд 19459.0, 2022 онд 20915.7 сая төгрөгийн орлогыг тус тус оруулж, 2023 оны 6 сарын байдлаар 13866.5 сая төгрөгийн орлого оржээ.

Орлогын гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт-3

/сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл	2021 он			2022 он			2023 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Илүү, дутуу	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Илүү, дутуу	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Илүү, дутуу
1	Газрын төлбөр	891.4	1213.0	321.6	1318.3	1611.9	293.6	1347.8	745.3	-602.5
2	Ойн нөөц ашигласны төлбөр	522.1	695.0	172.9	551.9	530.4	-21.5	551.6	106.4	-445.2
3	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	6.1	9.4	3.3	13.6	44.8	31.2	7.6	0.4	-7.2
4	Ус рашаан нөөц ашигласны төлбөр	14501.1	17538.2	3037.1	16258.0	18314.5	2056.6	27585.2	13014.2	-14571.0
5	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2.0	3.4	1.4	0.2	413.9	413.7	0.3	0.2	-0.1
Нийт дүн		15922.7	19459.0	3536.3	18142.0	20915.5	2773.5	29492.5	13866.5	-15626.0

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн дүнгээр 2021 онд 3536.3, 2022 онд 2773.5 сая төгрөгийн орлого илүү орсон нь тухайн жилийн орлогыг бодитой төлөвлөгдөөгүй байна.

Ус рашааны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 2021 онд 3037.1, 2022 онд 2056.6 сая төгрөгөөр давуулан биелүүлэхэд Бүрэгхангай, Орхон сум голлох нөлөө үзүүлсэн бол Баян-Агт, Булган, Дашинчилэн, Сайхан сумуудын орлогын төлөвлөгөө тасарчээ.

Усны төлбөр давж биелэхэд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дахин ашигладаг нуурын ус 2, 3 дугаар сард хөлдсөн, далангийн усны түвшин багассан зэргээс

¹⁹ Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

²⁰ Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

шалтгаалан саарал ус ашиглалт буурч Сэлэнгэ голоос ашиглах усны хэмжээ ихэссэнтэй холбоотой байна.

2022 онд ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг Засгийн газрын 351-р тогтоолоор бичил уурхайн үйл ажиллагааг зогсоосноос Бүрэгхангай сум 25.0 сая төгрөгөөр бууруулан, Сангийн яамны хянасан орлогоос шалтгаалан Баян-Агт сум 4.0, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашиглах усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 1777.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Рашаан ус ашигласны төлбөрийн орлогыг:

- Булган, Баян-Агт, Могод, Орхон, Сайхан, Хишиг-Өндөр сумдууд ахуйн ундраганы ус ашиглаж үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдээс,
- Бугат, Сэлэнгэ, Тэшиг сумд нь газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдээс,
- Бүрэгхангай, Хангал сумд нь бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг нөхөрлөл, нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас,
- Хутаг-Өндөр, Гурванбулаг, Рашаант сумд нь аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдээс төвлөрүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, үйлдвэрлэлийн зориулалттай усны нөөц ашигласны төлбөрийн 2021, 2022 онуудын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хавсралт-2 буюу 5 хүснэгтээр харуулсан болно.

Үйлдвэрлэл үйлчилгээний усны төлбөрийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг гүйцэтгэлд орж ирсэн Тамсаг баялаг ХХК, Эрдэнэт хивс ТӨҮГ зэрэг компаниудын усны дүгнэлт гаргуулаагүй, гэрээ байгуулаагүй үйл ажиллагаа явуулсан байна.

Үйлдвэрлэл үйлчилгээний усны орлого 2021 онд Эрдэнэт үйлдвэрээс усны дүгнэлтээр 18,567,138.8 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 14,443,119.0 мянган төгрөгөөр батлагдаж, 4,124,019.8 мянган төгрөгөөр дутуу баталсан байна.

Эрдэнэт үйлдвэр Төрийн өмчит үйлдвэрийн газар нь МУ-ын Засгийн газрын шийдвэрээр корона вируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, халдварын эрсдэлийг бууруулах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн, эдийн засгийг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд хэмнэлтийн горимоор ажиллаж, үйлдвэрлэлийн өртөг, зардлыг бууруулах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн, мөн Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан илүү ашигласан усанд торгууль ногдуулах зэргээс шалтгаалан жил бүр усны төлбөрийн гэрээг үндэслээгүйгээс өндөр төлөвлөж Сэлэнгэ голын сав газрын захиргаатай гэрээ байгуулдаг байна.

Гэтэл аймгийн ЗДТГ-ын СТСХ, Сангийн яам тус гэрээг үндэслэн суурь орлогыг төлөвлөж байгаагаас шалтгаалан аймгийн төсөвт төвлөрөх усны орлого тасрах шалтгаан болоод байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын 2021, 2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг хавсралт-2 буюу хүснэгт5-аар харуулсан болно.

Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 2021 онд аймгийн ИТХ-аар баталсан төлөвлөгөөнөөс давсан шалтгаан нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дахин ашигладаг нуурын ус 2, 3 дугаар сард хөлдсөн, далангийн усны түвшин багассан зэргээс шалтгаалан саарал ус ашиглалт буурч Сэлэнгэ голоос ашиглах усны хэмжээ ихэссэнтэй холбоотой байна.

Орлогын гүйцэтгэлийн дүнг ТЕГ-аас ирүүлсэн судалгааны дүнтэй тулгахад зөрүүтэй байна.

Зөрүүг хүснэгтээр харуулбал:

№	Орлогын төрөл	2021 он			2022 он		
		Аймгийн дүн	ТЕГ-ын дүн	Илүү, дутуу	Аймгийн дүн	ТЕГ-ын дүн	Илүү, дутуу
1	Ойн нөөц ашигласны төлбөр	695.0	685.2	9.8	530.4	529.0	-1.4
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	9.4	9.6	0.2	44.8	44.0	-0.8
3	Ус рашаан нөөц ашигласны төлбөр	17538.2	17507.0	-31.2	18314.5	18348.6	34.1
4	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	3.4	80.6	77.2	413.9	413.5	-0.4
Нийт дүн		18248.0	18201.8	-46.2	19303.6	19335.1	32.0

Аймгийн Татварын хэлтэс нь сар бүр орлогын тайлан мэдээг СТСХ-т хүргүүлэн ажиллаж байгаа ч аудитын явцад ТЕГ-аас аймгийн Татварын хэлтэст ямар нэгэн мэдээлэл өгөхгүй гэсэн чиглэл өгсний дагуу хүснэгтэд мэдээлсэн зөрүүний талаар асууж тулган баталгаажуулах боломж олгоогүй болно.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээгээр 17 сум, тосгоноор төлөвлөж батлуулан бүрдүүлж ажиллаж байгаа ч орлогын гүйцэтгэлд тавих хяналт сул, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллаагүй, илүү дутуу орлого төвлөрүүлсэн, газрын эзэмшил болон өмчлөлийн ногдуулалт, нэхэмжлэлийг дутуу үүсгэсэн, эзэмшлийн газрын “тин” дугаар үүсгээгүй, төлбөрийн ногдуулалтыг хийгээгүй зөрчлүүд илэрсэн нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2²¹, 23 дугаар зүйлийн 3²², Байгаль орчны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2.5²³, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3.8²⁴, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4²⁵ гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тухайлбал: Аудитын түүвэрт хамрагдсан Тэшиг, Хутаг-Өндөр сумдын байгаль хамгаалагч нарын 2021-2022 онуудын ойн нөөц, ан агнуурын орлогыг дансны хуулга, үнэт цаас, эрхийн бичгийн бүртгэлээр тулгасан горим сорилоор Тэшиг суманд байгалийн дагалдах баялаг буюу самрын 0.6, ан агнуурын 0.1, Хутаг-Өндөр суманд ойн нөөцийн орлогыг 0.3 сая төгрөгөөр тус тус төвлөрүүлээгүй нийт 1.0 сая төгрөгийн зөрчилд илэрлээ.

Мөн эзэмшлийн газрын 2022 оны тин дугаар үүсгээгүй 16 сумдын 1042 иргэн, аж ахуй нэгжийн 5.4 сая төгрөгийн газрын төлбөрийн ногдуулалтыг хийгээгүйд төлбөрийн акт, Баяннуур, Хишиг-Өндөр, Хангал, Баян-агт гэсэн 4 сумдын нийт 73 иргэний өмчлөлийн газрын, Булган, Дашинчилэн, Могод, Хангал, Хишиг-Өндөр сумдын 99 иргэн, аж ахуйн нэгжийн 1.3 сая төгрөгийн эзэмшлийн газрын ногдуулалт болон нэхэмжлэл үүсгээгүй зөрчлүүд илэрлээ.

Б2. Төлбөрийн орлогын хэсгийн хуваарилалтыг хуульд заасан хэмжээгээр төлөвлөөгүй байна.

Б.2.1. Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу 2023 онд төлөвлөсөн байна.

²¹ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ.

²² Сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан төлбөрийг бэлнээр хураан авсан тухай бүр сум, дүүргийн төсөвт тушаана.

²³ /Байгаль хамгаалагчийн ажлыг удирдан чиглүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар орон нутгийн төсөвтөө тусган хангах, шаардлагатай бусад туслалцаа үзүүлэх;

²⁴ газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу тодорхойлж ногдуулах

²⁵ Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавина.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг аймаг, сумд нь жил жилийн төсвийн орлогыг төлөвлөн батлуулж байгаа ч 2021-2022 онуудын төсвийн орлогыг төлөвлөж байгалийн нөөцийн нөхөн сэргээлтэд зарцуулах зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар 1²⁶ гэсэн заалтын дагуу хувь хэмжээгээр тооцож төлөвлөөгүй, тухайн онд хэрэгжүүлж ажиллах байгаль хамгаалах нөхөн сэргээх төсөл арга хэмжээний саналд үндэслэн зардлыг баталжээ.

Үүнд: Аймгийн ИТХ-ын 2020 оны II/09, 2021 оны V/04, 2022 оны XII/21 тоот тогтоолуудаар байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг 2021 онд 34 ажилд 4271.8, 2022 онд 41 ажилд 5248.4 сая төгрөг зарцуулахаар батлуулсан ч байгалийн нөөцийн төлбөрийн орлогын хэсгийн хувь хэмжээгээр хуваарилалтыг нарийвчлан тооцож хуваарилаагүй байна.

Харин 2023 оны аймгийн суурь зардлыг баталж өгсний дагуу байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулагдах зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөн сумын ИТХ-аар батлуулан ажиллажээ.

Хуваарилсан зардлыг хүснэгтээр харуулбал:

№	Орлогын төрөл	Орлогын дүн	Зарлагын дүн	Тооцсон хувь
1	Ойн нөөц ашигласны төлбөр	550.0	467.5	85%
2	Ус ашигласны төлбөр	35.7	12.5	35%
3	Газрын төлбөр	969.7	145.4	15%
4	Ан амьтны нөөцийн төлбөр	7.6	3.8	50%
5	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.3	0.05	15%
Нийт дүн		1563.3	629.3	

Байгалийн нөөцийн төлбөрийн орлогыг 2023 онд 1563.3 сая төгрөгөөр орлого төвлөрүүлэхээр төлөвлөж байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалд 629.3 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Б.2.2. Төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 2021, 2022 онуудад хуваарилаагүй, 2023 оноос эхлэн хуваарилжээ.

Аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зарцуулалтыг 2021 онд 34 төсөл арга хэмжээнд 4271.9, 2022 онд 41 төсөл арга хэмжээнд 5248.4 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 2021 онд 4131.1, 2022 онд 4240.9 сая төгрөгийг зарцуулжээ.

2022 онд 6 төсөл, арга хэмжээ нь огт хэрэгжээгүй байна.

Хэрэгжээгүй төсөл арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

д/д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	2022 онд санхүүжүүлэх /хуулиар батлагдсан/	Тайлбар
1	Шахмал түлшний үйлдвэр байгуулах (Сайхан сум)	500.0	Газрын байршил, ТЭЗҮ тодорхой болоогүй тул тендер шалгаруулалтыг зогсоосон
2	Булаг шандын эхийг хашиж хамгаалах (Баян-Агт, Орхон, Хишиг-Өндөр, Баяннуур, Булган, Бүрэгхангай,	68.0	Ажлын даалгавар ирээгүй байна

²⁶ "Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно."

	Дашинчилэн, Могод, Гурванбулаг сум)		
3	Хангал сумын цэвэр усны даралтат цамхаг барих	250.0	Зураг төсвийн үнэ санхүүжигдсэн. Гэрээ байгуулсан, гэрээний хугацаанд ажил хийгдээгүй тул гэрээ цуцалсан.
4	Хатуу хог хаягдлыг тээвэрлэх автомашинаар ээлж дараатай хангах (Баян-Агт, Гурванбулаг, Тэшиг сум, Хялганат тосгон)	200.0	Гэрээ байгуулсан. Импортын бараа нь хил гаалийн асуудлаас болж удааширсан байна.
5	Газрын хэвлийн, хөрсөнд учруулсан хохирлыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох	30.0	Мэргэжлийн байгууллагуудаас энэ төрлийн мэдээлэл, баримт ирээгүй тул санхүүжилт олгогдоогүй.
6	Нэн ховор, ховор, зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах	15.0	Цаг хугацааг хойшлуулж 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн байна.
Нийт дүн		1048.0	

Сумд нь байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг батлан ажиллаж байгаа ч төлөвлөсөн арга хэмжээний зардлыг батлагдсан төсөвт багтаан зарцуулдаггүй, илүү зарцуулалт хийгдсэн, зарим төлөвлөсөн ажил хийгдээгүй, анхан шатны баримт дутуу бүрдүүлсэн зөрчлүүд илэрсэн. Тухайлбал:

- Тэшиг сум нь 2022 онд 25 төсөл арга хэмжээнд сая төгрөг зарцуулахаар батлуулж гүйцэтгэлээр 4 ажил хийгдсэнээс нийтийн эзэмшлийн талбай цэвэрлэх иргэнд урамшуулал олгох 5.0 сая төгрөгийг 1.6, эргүүл шалгалтын шатахуун хоолны зардлын 4.0 сая төгрөгийг 0.1 сая төгрөгөөр тус тус илүү зарцуулсан.
- Хутаг-Өндөр сум нь 2022 онд байгаль хамгаалах хяналт шалгалтын шатахууныг 1.2 сая төгрөгөөр илүү зарцуулсан холбогдох анхан шатны баримтыг дутуу бүрдүүлж ажилласан зөрчил илэрсэн.

Уул уурхайн 2021, 2022 онуудад хийгдсэн нөхөн сэргээлтийг түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд аймгийн хэмжээнд 2021 онд 13 аж ахуйн нэгж, компани техникийн 69.4, биологийн 115.6 га газруудад, 2022 онд 14 аж ахуйн нэгж, компани техникийн 125.4, биологийн 90.2 га газруудад нөхөн сэргээлтийг хийснээс зарим компани нь үйл ажиллагаа явуулаагүй зогссон, шатахууны үнэ нэмэгдсэн зэрэг шалтгаанаар хийгдээгүй байна.

Үүнд: Уул уурхайн нөхөн сэргээлт дутуу хийсэн “Фокусметалл майнинг” ХХК нь 2022 оны 2.6 га, “Алтан гол эксплорэйшн” ХХК нь 2021 оны 2.7 га газруудад техникийн нөхөн сэргээлт хийгээгүй, “Монголросцветмет” ТӨҮГ-ын MV-000175 тоот талбайд нөхөн сэргээлт хийсэн боловч тухайн 120 м орчим газар нь эвдэрсэн зэрэг зөрчилд илэрлээ.

Уул уурхайн нөхөн сэргээлт хийгдээгүй газруудыг зургаар харуулбал:



/Алтан гол эксплорайшн ХХК/



/Монголросцветмент/ ТӨҮГ

Уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа томоохон компаниудаар дүйцүүлэн хамгаалах хүрээнд нөхөн сэргээлтийн ажлуудыг хийлгэж байгаа ч нөхөн сэргээлт хийгдсэн газарт эрх олгосноор бичил уурхайнууд үйл ажиллагаа явуулж байгаа нь нөхөн сэргээлт хийхгүй орхигдох эрсдэл үүсэх магадлалтай байна.

Ойрын жилүүдэд нөхөн сэргээлт хийгдээгүй эзэнгүй орхигдсон газрын судалгааг 2006-2019 онуудад авто зам болон хууль бусаар олборлосон, эзэн холбогдогч нь тодорхойгүй газруудын судалгааг гаргаж ажилласан, энэхүү судалгаагаар 34 газрын 810 га газрыг тодорхойлж бүртгэл хийсэн боловч нөхөн сэргээлт хийх тал дээр арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Орхигдсон эзэн холбогдогч тогтоогдоогүй газруудаас товч дурдвал: Бүрэгхангай сумын нутагт байрлах Төсөлчдийн урд талд 32 га, Сөөгийн дэнж 39 га, Өгөөмөр-2 15 га, Артамсаг-1 26 га, Артамсаг-2 18 га, Баяннолын голидрол 26 га, Орхон сум Халиун баг залуугийн хөтөл 35 га, Арбулаг баг Өлзийт Орхон 180 га, Сайхан сум Сайхан уул хуучин уурхай 37 га гэсэн газрууд тус тус тогтоогдсон байна.

В.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, хийж үр дүнг тооцоогүй байна.

В.1. Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан үнэн зөв илэрхийлэгдээгүй, төрийн байгууллагуудын цахим мэдээллийн сан уялдаагүйгээс зөрүүтэй тайлагнагдаж байна.

В1.1 Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан бүрдүүлэлт, ил тод байдал хангагдсан ч журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлыг цахим мэдээллийн санд байршуулна гэж заасан байна.

Булган аймгийн хувьд байгалийн нөөцийн ус рашаан, байгалийн ургамал, амьтны гэсэн 3 төрөлд мэдээлэл бүрдүүлэлтийг авч үзэв.

Үүнд: Аймгийн БОАЖГ-аас <http://eic.mn/finance/> цахим системд төлөвлөлтийн хэсгийн 6 маягт, гүйцэтгэлийн хэсгийн 4 маягт нийт 12 маягтаар тухайн жилийн мэдээг оруулахаар хуульчлагдсан байна.

Аудитаар 2022 оны мэдээ бүрдүүлэлтийг үзэхэд мэдээллийг дутуу оруулсан, оруулсан мэдээнд зарим үндэслэх баримт бичгийн заалтыг оруулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-аар зохицуулагдаж байгаа бөгөөд тус журмын хэрэгжилт хангалтгүй үүсэлтэй байна. /<http://eic.mn/finance> цахим системийн мэдээ оруулалтын байдлын хавсралт-3 буюу хүснэгт №9 харуулсан болно./

В1.2 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаатай ч цахим мэдээллийн сан, системүүд хоорондоо уялдаа холбоогүй байна.

Аймгийн усны нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл нь санхүү төрийн сангийн мэдээ, татварын газрын мэдээ, БОАЖГ-ын <http://eic.mn/finance/> цахим системд оруулсан мэдээнүүд зөрүүтэй байгаа нь төрийн байгууллагын хамтын ажиллагаа уялдаа холбоо хангалтгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-10 Усны нөөц ашиглалтын мэдээллийн зөрүү

/сая төгрөг/

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл			Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын гүйцэтгэл	
Аймгийн санхүү, төрийн сангийн мэдээгээр орлогын гүйцэтгэлийн дүн	Татварын газрын мэдээгээр орлогын гүйцэтгэлийн дүн	Аймгийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системд орлогын гүйцэтгэлийн мэдээг оруулсан дүн	Аймгийн санхүү, төрийн сангийн зарцуулалтын гүйцэтгэлийн дүн	Аймгийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системд зарцуулсан гүйцэтгэлийн мэдээг оруулсан дүн
18310.1	18310.1	16500.0	5010.8	235.9

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын <http://eic.mn/finance/> цахим систем, татварын газрын цахим систем, санхүү төрийн сангийн цахим мэдээллийн сан зэрэг системүүд нь тус тусдаа ажиллагаатай хоорондоо холбоогүй байгаа нь мэдээллийн зөрүү гарч байгаагийн нэг шалтгаан болж байна.

В.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийсэн боловч үр дүн хэрэгжилтийг тооцож дүгнээгүй байна.

В2.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн байгууллага нь байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт, шалгалт хийгдсэн боловч үр дүн хэрэгжилтийг тооцоогүй байна.

Аймгийн хэмжээнд “Нөхөн сэргээлт-2021” нэгдсэн арга хэмжээний дагуу Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газартай хамтран аймгийн ЗД-ын 2021 оны А/115, А/370 тоот, 2022 оны А/577, А/475, А/663 тоот захирамж гарч хяналт шалгалтыг Засаг даргын орлогчоор ахлуулан ойн түймрээс сэргийлэх зорилгоор 8 суманд, уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтийн явцыг Бүрэгхангай, Дашинчилэн сумдын нутаг дэвсгэрт уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч 13 нэгж хамруулж 5 удаагийн хяналт шалгалтуудыг тус тус явуулсан байна.

Хяналт шалгалтаар уул уурхайтай холбоотой 4 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг улсын ахлах байцаагчийн актаар түр зогсоож, 2 аж ахуйн нэгжид 288.2 сая төгрөгийн нөхөн төлбөр, 7 аж ахуйн нэгжид 40.5 сая төгрөгийн торгууль ногдуулж, улсын ахлах байцаагчийн албан даалгавар хүргүүлсэн байна.

Мөн ойн хээрийн түймрээс сэргийлэх зорилгоор морин эргүүлээр 3 удаагийн сум дундын ойн ангитай хамтарсан 19 удаагийн шалгалтаар 77.5 сая төгрөгийн нөхөн төлбөр, 3.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, хяналт шалгалтыг эрчимтэй зохион байгуулж орон нутгийн төсөвт орох орлогыг нэмэгдүүлэн ажилласан гэх боловч тус хяналт шалгалтыг дүгнэж хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.

В2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хүрээнд хамтарсан хяналт шалгалт хийсэн нь үр дүн хэрэгжилтийг тооцож баримтжуулаагүй байна.

Аймгийн хэмжээнд Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын 3 дахь заалтын 17-д²⁷, 3 дугаар зүйлийн 18-д²⁸, 3 дугаар зүйлийн

²⁷ Байгалийн ургамал, амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, байгаль орчны мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

²⁸ Ус, рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг усны сав газрын захиргаатай хамтран хэрэгжүүлнэ.

19-д²⁹, 3 дугаар зүйлийн 20-д³⁰ гэсэн заалтуудын дагуу 2021-2022 онуудад мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалтыг аймгийн хэмжээнд хийж ажилласан ч хэрэгжилтийг тооцоогүй байна.

Аймгийн ИТХ-аас 2022 оны ИТХ-ын XII/21 дүгээр тогтоолоор уул уурхайн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг зохион байгуулж ажиллахаар батлуулжээ.

2023 онд Зэд-хантай-бүтээлийн нурууны Дархан Цаазат газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах гэрээг байгуулж, Тэшиг сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчтай дархан цаазат газрын орчны бүсэд 3 удаагийн хяналт шалгалт хийхэд зөрчил илрээгүй байна.

Цаашид аймгийн ИТХ нь байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хийгдэх хяналт шалгалтыг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу бүрэн хийж ажлын тайлан мэдээг баталгаажуулан хэрэгжилтийг тооцон ажиллах шаардлагатай байна.

Аудитаар нийт 7.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 6.5 сая төгрөгт 3 төлбөрийн акт, 1.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 4 албан шаардлага өглөө.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүн, тайланд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь зарим хууль тогтоомж болон эрх зүйн акттай нийцэхгүй байна.
- Иргэн, хуулийн этгээд байгалийн усны нөөцийг дүгнэлт гаргуулаагүй, зөвшөөрөлгүй ашиглаж байна.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөөгүй, ногдуулаагүй, бүрэн төвлөрүүлээгүй байна.
- БОАЖЯ-ны сайдын 2020 оны А/701 тоот тушаалаар баталсан “тусгай болон ахуйн зориулалтаар агнах, барих амьтдын дээд хязгаарт загас агнуурыг тоо”-г 1500 ш-ээр тогтоосныг аймгийн ИТХ-р 2021 онд ахуйн зориулалтаар загас агнах, барих тоо хэмжээг 1700 буюу 200 ш илүү баталсан.
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг бодитой төлөвлөгөөгүй, өмнөх оны дундаж гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөдөг.
- Усны төлбөрийн орлогыг ой болон бэлчээрийг хамгаалах ажилд төлөвлөснөөс усны нөөц тогтоох ажил хэрэгжээгүй, хөрөнгө санхүүжилт хүрэлцэхгүй байна.
- “Аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулалт хийх, агнуурын амьтдын тархац, нөөц” тогтоосон тайлангийн тоо мэдээнд үндэслэн төлөвлөж батлаагүй.
- Эзэмшлийн газрын 2022 оны тин дугаар үүсгээгүй 16 сумдын 1042 иргэн, аж ахуй нэгжийн 5.4 сая төгрөгийн газрын төлбөрийн ногдуулалтыг хийгээгүй.
- Баяннуур, Хишиг-Өндөр, Хангал, Баян-Агт гэсэн 4 сумдын нийт 73 иргэний өмчлөлийн газрын, Булган, Дашинчилэн, Могод, Хангал, Хишиг-Өндөр сумдын 99 иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшлийн газрын ногдуулалт болон нэхэмжлэл үүсгээгүй дутуу.
- 2021, 2022 онд хийгдэх Уул уурхайн нөхөн сэргээлт хийгдээгүй дутуу байна.
- Байгалийн нөөцийн төлбөрийн орлогын 1.0 сая төгрөгийг дутуу, төвлөрүүлээгүй.

²⁹ Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг сум дундын ойн анги, ойн нөхөрлөл, байгаль орчны мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

³⁰ Газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлэг, малчид, ойн нөхөрлөл, орчны бүсийн зөвлөлтэй хамтран хэрэгжүүлнэ.

- Сумдын байгаль хамгаалагч нарын үнэт цаасны тооцоог хийж баталгаажуулдаггүй, өмнөх онуудын анхан шатны баримт үдэгдээгүй задгай, ажил хүлээлцсэн акт үйлдээгүй, эзэнгүйдэж байна.
- Сумд нь байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөж батлагдсан төсөвт багтаан зарцуулдаггүй, төлөвлөсөн ажлууд дутуу хийгдсэн байна.
- eic.mn/finance/ цахим системд мэдээг нутгийн өөрөө удирдах байгууллагад танилцуулаагүй, мэдээллийн бүрдэл дутуу, зөрүүтэй, буруу тайлагнасан.
- Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хурлын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардлыг бүрэн батлаагүй.
- Аймгийн ИТХ-аар байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн ажлын үр дүнг хэрэгжилтийг тооцож ажилласан ажлын тайланг баримтжуулж ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын Дарга Д.Эрдэнэбат танаа:

- ✓ Сумдад байгалийн нөөцийг тогтоох, ашиглах төрөл, дээд хэмжээг БОАЖ-ийн Сайдын тушаалын дагуу тогтоох.
- ✓ Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын үр дүнг тооцож хэрэгжилтийг тооцож байх
- ✓ Усны нөөц тогтоох, нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хуульд заасны дагуу тогтоох.

Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ танаа:

- ✓ Аймгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага болон усны сав газрын захиргааны саналыг үндэслэн сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд төсвийг батлуулах.
- ✓ Уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдэрсэн, эзэнгүй орхигдсон газруудын тоо хэмжээг тоолох, тооллогын ажлыг зохион байгуулан үр дүнг тооцох.
- ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээнд тавих дотоод хяналтыг сайжруулах.
- ✓ Сумдын Засаг дарга нарт байгаль хамгаалагч нарын дотоод ажлыг сайжруулах үүрэг чиглэл өгч ажиллах тал дээр арга хэмжээ авч ажиллах.

Аймгийн БОАЖГ-ын дарга А.Гантөмөр танаа:

- ✓ Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлийг дүгнэж ажиллах.
- ✓ Хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар рашаан-эмчилгээ, сувилгааны зориулалтаар рашааны ус ашиглуулах дүгнэлтийг бүрэн гаргаж хэрэгжүүлэх.
- ✓ eic.mn/finance/ цахим системд мэдээг нутгийн өөрөө удирдах байгууллагад танилцуулж, мэдээллийн бүрдлийг ханган үнэн зөв мэдээ тайлагнаж байх.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт

Хавсралтууд:

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө:

Хавсралт-1

Хүснэгт-4

/сая.төг/

№	Сумдын нэрс	2021 он			2022 он			Өмнөх оноос гарсан өөрчлөлт
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	зөрүү /Өссөн +, Буурсан - /	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	зөрүү /Өссөн +, Буурсан - /	
1	Булган аймаг	14443.1	14443.1	-	15739.2	16220.2	481.0	1777.1
2	Баян-агт	8.0	8.0	-	12.0	12.0	-	4.0
3	Бугат	15.0	15.0	-	1.5	1.5	-	-
4	Булган	4.0	4.0	-	4.0	4.0	-	-
5	Баяннуур	-	-	-	-	-	-	-
6	Бүрэгхангай	25.0	25.0	-	-	-	-	(25.0)
7	Гурванбулаг	0.06	0.06	-	0.06	0.06	-	-
8	Дашинчилэн	1.0	1.0	-	1.0	1.0	-	-
9	Могод	4.0	32.0	(0.8)	4.0	4.0	-	0.8
10	Орхон	0.9	0.9	-	0.9	0.9	-	-
11	Рашаант	3.2	3.2	-	3.2	3.2	-	-
12	Хялганат	-	-	-	-	-	-	-
13	Сайхан	1.0	1.0	-	1.0	1.0	-	-
14	Сэлэнгэ	1.0	1.0	-	1.0	1.0	-	-
15	Тэшиг	0.2	0.2	-	0.2	0.2	-	-
16	Хангал	6.1	6.1	-	6.1	6.1	-	-
17	Хишиг-Өндөр	0.2	0.2	-	0.2	0.2	-	-
18	Хутаг-Өндөр	2.5	2.5	-	2.5	2.5	-	-
	Нийт дүн	14501.9	14501.1	(0.8)	15777.0	16258.0	481.0	1756.9

Үйлдвэрлэлийн зориулалттай усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хавсралт-2

Хүснэгт-5

/сая.төг/

д/д	Татвар төлөгчийн нэр	2021 он			2022 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Монполимет	130.0	148.4	18.3	150.0	206.1	56.1
2	АЛТАНГОЛ ЭКСПЛОРЭЙШН	100.0	75.0	(25.0)	75.0	120.2	45.2
3	ГБНБ	35.0	33.3	(1.6)	33.0	35.1	2.1
4	Өгөөж баян хангай	6.0	26.4	20.4	26.0	34.2	8.2
5	Бүрдэлмайнинг	50.0	43.5	(6.5)	40.0	38.4	(1.6)
6	Шар нарст	30.0	31.9	1.9	30.0	25.2	(4.8)
7	Тэргүүн майнинг	50.0	169.9	119.9	70.0		(70.0)
8	Шижир алт /Монголросцветмет/	324.0	313.3	(10.6)	300.0	61.4	(238.5)
9	Хоту	6.0	7.7	1.7	7.0	5.3	(1.6)
10	Платинумланд	29.0	30.3	1.3	30.0	52.9	22.9

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт

11	Тэнгэрийн хорвоожинг	15.0	15.3	0.2	15.0		(15.0)
12	Эрдэнэт үйлдвэр	13568.1	16440.9	2872.8	15340.4	17130.1	1789.6
13	Эрдэнэтийн дулаан цахилгаанст	80.0	88.0	8.0	80.0	122.0	42.0
14	Эрдэнэт хивс		3.1	3.1	3.0	3.1	0.1
16	Тамсаг баялаг		5.8	5.8			-
17	Улаанбухнууд		4.2	4.2			-
18	ЭРДЭНЭТ УС ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭ	20.0	21.5	1.5	21.0	26.3	5.3
19	Батбродерс майнинг			-		438.9	438.9
20	ФОКУСМЕТАЛ МАЙНИНГ			-		2.6	2.6
21	ХАМТЫН ЭХ БУЛАГ			-		8.0	8.0
Нийт дүн		14443.1	17458.9	3015.7	16220.4	18310.1	2089.6

Хавсралт -3

/Хүснэмт №5 <http://eic.mn/finance/> цахим системийн мэдээ оруулалтын байдал

Д/д	Маягтын дугаар	Мэдээний нэр	Журамд заагдсан хугацаа сар/өдөр	Мэдээлсэн эсэх /тийм, үгүй/	Нөөцийн төрлөөр мэдээлсэн байдал /тийм, үгүй/			тайлбар
					Ус, рашаан	Ургамал	Амьтан	
Аймгийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системийн төлөвлөлтийн мэдээ								
1	Маягт 3	Аймгийн төсөвт төвлөрүүлэх БНАТ-ийн орлогын төлөвлөгөө	VII/25	тийм	тийм	үгүй	үгүй	Бүрэн мэдээлсэн
2	Маягт 4А	Аймгийн БНАТ-ийн орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНСАХ-ий төлөвлөгөө		тийм	тийм	үгүй	үгүй	Арга хэмжээг төлөвлөх үндэслэлийн МТ дутуу
3	Маягт 5	Аймгийн БНАТ-ийн нийт орлогын төлөвлөгөө	VIII/01	тийм	үгүй	үгүй	үгүй	Бүрэн мэдээлсэн
4	Маягт 6А	Аймгийн БНАТ-ийн орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНС нийт арга хэмжээний төлөвлөгөө		тийм	үгүй	үгүй	үгүй	Бүрэн мэдээлсэн
5	Маягт 4Б	Аймгийн БНАТ-ийн давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНСАХ-ний төлөвлөгөө	XI/15	тийм	тийм	үгүй	үгүй	Бүрэн мэдээлсэн

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт

6	Маягт 6Б	Аймгийн БНАТ-ийн давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНС нийт арга хэмжээний төлөвлөгөө	XI/20	үгүй	-			Бүрэн мэдээлсэн
7	Маягт 4	Аймгийн төсвийн БНАТ-ийн орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНСАХ-ий нэгтгэл төлөвлөгөө	XI/20	тийм	тийм	үгүй	үгүй	Бүрэн мэдээлсэн
8	Маягт 6	Аймгийн БНАТ-ийн орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНСАХ-ий нэгтгэл төлөвлөгөө	XI/20	тийм	үгүй	үгүй	үгүй	Бүрэн мэдээлсэн
Аймгийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системийн гүйцэтгэлийн мэдээ								
9	Маягт 9	Аймгийн төсөвт төвлөрүүлсэн БНАТ-ийн орлогын гүйцэтгэл тайлан	I/15	тийм	тийм	үгүй	үгүй	Мэдээлэл дутуу / 1 компаний мэдээлэл оруулсан/
10	Маягт 10	Аймгийн төсөвт төвлөрүүлсэн БНАТ-ийн орлогын хэсгийн зарцуулалтын тайлан		тийм	тийм	үгүй	үгүй	Бүрэн мэдээлсэн
11	Маягт 11	Аймгийн БНАТ-ийн нийт орлогын гүйцэтгэлийн тайлан	I/20	тийм	үгүй	үгүй	үгүй	Бүрэн мэдээлсэн
12	Маягт 12	Аймгийн БНАТ-ийн орлогын хэсгийн нийт зарцуулалтын тайлан		тийм	тийм	үгүй	үгүй	Бүрэн мэдээлсэн

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын код: ГАА-2023/30-ШТА-НА

Аудитын нэр: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хэрэгжилт /2021-2023 он/
Байгууллагын нэр: Булган аймаг дахь Төрийн аудитын газар

№	Аудитын зорилт, чиглэл	3	4	5	8	Гаргасан шийдвэр
1	Байгалийн ургамлын нөөцийн төлбөрийн 2022 оны орлого буюу самар, ан амьтны 678.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.	Алдаа, зөрчлийн товч утга	678.00	Төлбөрийн акт тогтоох	Хүлээн зөвшөөрсөн.	Төлбөрийн акт тогтоох
2	Байгалийн ургамлын нөөцийн төлбөрийн 2021-2022 оны орлого буюу гоожингийн 258.3 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна. 2022 оны шинээр эзэмшлийн газар олгосон газрын төлбөрийн ногдуулалтыг тулгаран горим сорилгоор 1042 иргэн, аж ахуйн нэгжийн тин дугаарыг үүсгээгүй, газрын төлбөрийн 5386.8 мянган төгрөгийн ногдуулалтыг дууруу үүсгэсэн байна.		258.30	Төлбөрийн акт тогтоох	Хүлээн зөвшөөрсөн.	Төлбөрийн акт тогтоох
3	Ан амьтны нөөцийн орлогыг ирээдэс илүү тооцон авч төсөвт 185.0 мянган төгрөгийн орлого илүү тушаасан.		5,386.80	Төлбөрийн акт тогтоох	Хүлээн зөвшөөрсөн.	Төлбөрийн акт тогтоох
4	2022 оны шинээр өмчлөлийн газар олгосон иргэн, аж ахуйн нэгжийг захиралж гарсан өдрөөр бүртгээгүй, төлбөрийн ногдуулалт болон нэхэмжлэлийг үүсгээгүй.		185.00	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Албан шаардлага өгөх
5	2022 оны шинээр эзэмшлийн газар олгосон иргэн, аж ахуйн нэгжийг захиралж гарсан өдрөөр бүртгээгүй 1,345.4 мянган төгрөгийн газрын төлбөрийн ногдуулалт болон нэхэмжлэлийг үүсгээгүй.		1,345.30	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Албан шаардлага өгөх
6	Уул уурхайн үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, компани нь 2021, 2022 онуудад уул уурхайн нөхөн сэргээлт хийгээгүй, нөхөн сэргээлт хийсэн газар нь эвдэрсэн байна.		-	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Албан шаардлага өгөх
7	Сүмдэд байгалийн нөөцийг тогтоох, ашиглах төрөл, дээд хэмжээг БОАЖ-ийн Сайдын тушаалын дагуу тогтоогоогүй.		-	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж өгөх
8	Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шаалгалтын үр дүнг тооцож хэрэгжилтийг тооцоогүй.		-	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж өгөх
9	Усны нөөц тогтоох, нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хуульд заасны дагуу тогтоогоогүй.		-	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж өгөх
10	Албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ		-	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж өгөх
11	Уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдэрсэн, эзэнтэй орхигдсон газруудын тоо хэмжээг тоолох ажлыг хийсэн ч үр дүнг тооцоогүй.		-	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж өгөх
12	Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллаагүй.		-	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж өгөх
13	Сүмдэн засаг дарга нарт байгаль хамгаалагч нарын дотоод ажлыг сайжруулах үүрэг чиглэл өгч ажиллаагүй.		-	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж өгөх
14	Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж гүйцэтгэлийг дүгнэж ажиллаагүй байна.		-	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж өгөх

16	Хүн амын үнд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар рашаан-эмчилгээ, сувилгааны зориулалтаар рашааны ус ашиглуулах Дүгнэлтийг бүрэн гаргаж хэрэгжүүлээгүй.	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж өгөх
17	ӨС.тп/Inpase/ цахим системд мэдээг нутгийн өөрөө удирдах байгууллагад танилцуулж, мэдээллийн бүрдлийг ханган үнэн зөв мэдээ тайлагнасан нь зөрүүтэй байна.	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж өгөх
Нийт дүн				7,853.4

Бэлтгэсэн:

Ахлах аудитор
Ахлах аудитор
Аудитор
Аудитор

П.Мөнхтуяа
А.Анхбаяр
Золжаргал
Г.Цэрэнлхам

Анхан шатанд хянасан:
Аудитын менежер

(Signature)

Хоёр дахь шатанд хянасан:
Тэргүүлэх аудитор

(Signature)
Б.Эрдэнэ

ГТД/048/3180269

Огноо:
Огноо:
Огноо:
Огноо:
Огноо:
Огноо:

2023-06-19



БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2023 оны 05 дугаар сарын 31

Дугаар 01/129

